

**“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 01/25

Улаанбаатар хот

**Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн
дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Булигаар ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалт, Булигаар ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТТҮШИГ

**“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 02/25

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны зардлын төсөв батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Булигаар ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны 25/02 ЦУХ тоот тогтоол, 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**


- Нэг. Булигаар ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийг Нэгдүгээр хавсралтад заасны дагуу баталсугай.
- Хоёр. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, цалин хөлс, урамшууллыг үр дүнг харгалзаж олгож байхыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТТУШИГ

Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн
02/25 тоот тогтоолын Нэгдүгээр хавсралт



ТУЗ-ИЙН 2025 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Тоо	Давтамж	Нэгж зардал	Дүн
Цалин, урамшууллын зардал					
1	ТУЗ-ийн ердийн гишүүний цалин	6	10		-
2	ТУЗ-ийн хараат бус гишүүний цалин	3	12	250,000	9,000,000
3	ТУЗ-ийн нарийн бичиг	1	12		-
	Хэсгийн дүн				9,000,000
Бичиг хэрэг, хурлын зардал					
1	МХБ-ийн үйлчилгээний хураамж	1	1	500,000	500,000
2	ҮЦТХТ ХХК-д хувьцааны хадгаламжийн хөлс	1	1	500,000	500,000
3	ҮЦТХТ ХХК-д ногдол ашиг тараалгах хураамж	1	1	100,000	100,000
4	Санхүүгийн тайланд аудит хийх ажлын хөлс	1	1	6,000,000	6,000,000
6	ҮЦТХТ ХХК-д таргалтын мэдээ	1	1	121,700	121,700
7	ХЭ-ийн хурлын зар өгөх	2	2	200,000	800,000
8	Хурлын материал бэлтгэх зардал	1	1	300,000	300,000
9	ХЭ-д өгөх гарын бэлэг	20	1	30,000	600,000
10	Бичиг хэрэг, цай кофены зардал	1	1	300,000	300,000
	Хэсгийн дүн				9,221,700
НИЙТ ДҮН					18,221,700

Тайлбар: Энэхүү төсөв нь 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараа жилийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд хамаарна.

**“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 03/25

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалт, Булигаар ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.1, 7.18, 7.19 дэх заалт, 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах гишүүдийн бүрэлдэхүүнээр улируулан сонгосугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Төмөрбаатарын Болд
Чулуунбаатарын Нямдорж
Жадамбын Эрдэнэбат

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

Батчулууны Анхболд
Анхболдын Энхмэнд
Батчулууны Баянжаргал
Довжидын Гансүх
Бямбабаярын Баттүшиг
Цэрэндагвын Мөнхлхагва

Хоёр. Компанийн дүрмийн 7.19-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил буюу дараа жилийн компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл үргэлжлэхийг дурдсугай.

Гурав. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад дүрэм журмуудыг мөрдөж ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТТҮШИГ